



ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

“АХМАД НАСТНЫ ТУХАЙ ХУУЛИЙН 14.7 ДАХЬ ХЭСГИЙН ХЭРЭГЖИЛТ, ТҮҮНИЙ ҮР ДҮН”

Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-т заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Монгол Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2024 оны 05 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2024 оны А/108 дугаар тушаалыг үндэслэн судалгааны түвшинд гүйцэтгэлээ.

Дорноговь аймгийн хэмжээнд төсвийн шууд захирагчийн 168 байгууллага үйл ажиллагаа явуулдаг бөгөөд 98 байгууллага нь ахмадын сангийн харилцах данстай байна. Ахмадын сангийн харилцах данстай боловч санд орлого, зарлагын гүйлгээ хийгддэггүй 6 байгууллага байна.

Идэвхтэй үйл ажиллагаа явуулж буй 92 байгууллагыг төсвийн ерөнхийлөн захирагчаар нь ангилбал:

Хүснэгт 1. Төрийн байгууллагуудын ахмадын сангийн 2024 оны гүйлгээний нэгтгэл

№	Төсвийн ерөнхийлөн захирагч	Байгууллагын тоо	Эхний үлдэгдэл	Орлого	Зарлага	Эцсийн үлдэгдэл
1	Дорноговь аймгийн Засаг дарга	19	159,455,457	76,484,053	80,761,121	155,178,389
2	Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд	3	26,419,536	65,408,000	13,158,153	78,669,383
3	Боловсролын сайд	38	428,294,509	367,101,377	225,277,332	570,118,554
4	Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд	2	13,674,600	13,250,647	9,130,792	17,794,455
5	Олимп, нийтийн биеийн тамир спортын сайд	1	1,269,570	14,283,864	1,200,000	14,353,434
6	Сангийн сайд	1	35,951,540	24,600,000	17,300,000	43,251,540
7	Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайд	9	52,023,573	60,536,985	28,059,160	84,501,397
8	Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд	1	-	5,000,000	3,240,000	1,760,000
9	Хууль зүй, дотоод хэргийн сайд	4	66,671,567	33,375,169	36,248,386	63,798,349
10	Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн сайд	2	11,986,574	11,467,801	10,024,224	13,430,151
11	Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга	2	30,286,023	-	13,032,990	17,253,033
12	Эрүүл мэндийн сайд	10	96,900,601	30,402,215	35,375,650	91,927,166
	НИЙТ	92	922,933,550	701,910,111	472,807,808	1,152,035,852

Эх сурвалж: Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газрын нэгдсэн судалгаа

Ахмадын сантай төсөвт байгууллагын 20.6 хувийг орон нутгийн байгууллага байгаа бол 79.4 хувь нь улсын төсөвт байгууллага байна.

Улсын төсөвт байгууллагуудын 41.3 хувь нь боловсролын салбарын байгууллага бөгөөд нийт сангийн үлдэгдлийн 49.4 хувийг тус тус эзэлж байна.

ОРЛОГО:

Нийт 92 байгууллагын ахмадын санд 2024 онд 701.9 сая төгрөгийн орлого төвлөрсөн бөгөөд энэ нь цалингийн нийт сангийн 3 хүртэлх хувьтай тэнцэх хэмжээгээр ахмадын санд төвлөрүүлсэн хөрөнгөөс бүрдүүлсэн байна. Хууль заагдсан хэмжээнээс илүү дүнгээр сангийн эх үүсвэрт төвлөрүүлсэн, эсхүл хуульд заагдаагүй эх үүсвэрээс бүрдүүлсэн зөрчил илрээгүй болно.

ЗАРДАЛ:

Нийт 92 байгууллагын ахмадын сангаас 2024 онд 472.8 сая төгрөгийн зарцуулалт хийгдсэн бөгөөд зарцуулалтыг ангилбал дараах байдалтай байна.

Хүснэгт 2. Төрийн байгууллагуудын ахмадын сангийн 2024 оны зарцуулалтын ангилал

№	Зарцуулалтын ангилал	Мөнгөн дүн	Эзлэх хувь (%)
1	Байгууллага, салбартаа онцгой үр бүтээл гарган олон жил идэвх зүтгэлтэй ажилласан ахмад настанд нэмэгдэл тэтгэвэр, тэтгэмж, буцалтгүй тусламж олгох;	42,695,200	9.03
2	Цагаан сар, ахмадын өдрийг тохиолдуулан хүндэтгэл үзүүлэх, бэлэг дурсгалын зүйл гардуулах;	337,629,616	71.41
3	Нийтийн халаалтгүй сууц, гэрт амьдардаг ахмад настанд түлш худалдан авахад зориулан мөнгөн дэмжлэг үзүүлэх;	27,611,542	5.84
4	Хувиараа хөдөлмөр эрхлэх болон үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлж байгаа ахмад настанд санхүүгийн дэмжлэг үзүүлэх;	2,415,500	0.51
5	Шинээр хашаа, байшин барих, засварлах, орон сууцныхаа нөхцөлийг сайжруулахад зориулж ахмад настанд дэмжлэг үзүүлэх;	1,382,750	0.29
6	Эрүүл мэндийн шалтгаанаар удаан хугацаагаар өвчтэй байгаа ахмад настанд эмчилгээний зардалд зориулж мөнгөн тусламж үзүүлэх;	17,778,000	3.76
7	Ахмад настан өөрөө эсхүл, түүний нөхөр (эхнэр) нь нас барсан тохиолдолд мөнгөн тусламж олгох;	21,080,000	4.46
8	Ахмадуудын дунд идэвхтэй насжилтыг дэмжих амралт, аялал, урлаг, спортын арга хэмжээ, уралдаан тэмцээн зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх;	22,065,200	4.67
9	Амьжиргааны баталгаажих төвшингээс доогуур орлоготой, нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай болон харж хандах ах дүү, төрөл садангүй, ганц бие ахмад настанд мөнгөн тусламж үзүүлэх;	150,000	0.03
10	Хуульд заасан хүрээнд ахмад настанд чиглэсэн бусад хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэх.	-	0.00
НИЙТ		472,807,808	100.00

Эх сурвалж: Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газрын нэгдсэн судалгаа

Дээрхээс харахад, дийлэнх байгууллага нь цагаан сар, ахмадын өдрийг тохиолдуулан хүндэтгэл үзүүлэх, бэлэг дурсгалын зүйл гардуулахад сангийн хөрөнгийг зарцуулж байна.

Сангийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулсан зөрчил **илрээгүй** болно.